

ГЕРМАН ХЭЛНИЙ ӨВӨРМӨЦ ХЭЛЦИЙГ ГАРАЛ ҮҮСЛЭЭР НЬ ТАЙЛБАРЛАХ НЬ

А.Цэрэнчулуун⁵²

Kurze Übersicht: *Jede Sprache hat ihre eigenen spezifischen Redewendungen (Idiome) – Satzteile oder auch nur Wortverbindungen –, die oft nicht wortwörtlich in eine andere Sprache übersetzt werden können. Sie stellen eine der vielen Möglichkeiten dar, die Kommunikation untereinander zu personalisieren.*

Ein Idiom, technisch als „formelhafte Sprache“ kategorisiert, ist ein spezieller Ausdruck oder eine Redewendung, die eine übertragene Bedeutung besitzt, die sich von der wörtlichen Bedeutung unterscheidet.

Diese Wortverbindungen oder Satzteile entstanden in bestimmten historischen Zeitabschnitten innerhalb bestimmter Berufsgruppen oder bestimmten gesellschaftlichen Situationen. Im Verlauf der gesellschaftlichen Entwicklung ging oftmals dieser ursprüngliche Zusammenhang verloren. Die Idiome selbst aber blieb erhalten und wurden zur Redewendung für einen heute nur im übertragenen Sinn gleichen Sachverhalt. Redewendungen verweisen in der Regel auf eine vergangene gesellschaftliche Wirklichkeit, die den Menschen, die die Redensart heute benutzen, oft gar nicht mehr bewusst ist.

In diesen Redewendungen ist vielfach die Vergangenheit, die spezifischen Erfahrungen und die Entwicklung einer ganzen Kultur „versteckt“.

Um eine Redewendung richtig zu verstehen und richtig zu verwenden, muss man die Entstehungsgeschichte der jeweiligen Redewendung kennenlernen. Dies ist insbesondere bei der Übersetzung solcher Redewendungen in eine andere Sprache von großer Bedeutung. In diesem Artikel versuche ich die Entstehungsgeschichte einiger Redewendungen nachzuzeichnen und so ihren Sinn deutlich zu machen und ein mongolisches Äquivalent zu finden.

Түлхүүр үгс: *Өвөрмөц хэли, үйлний хайрцаг, үйлний хайч, гар нийлэх, тэнгэрийн хишиг хүртэх; ханцуйдаа залбирах; дээлийн нь захыг мушгих, хусмаа чамласан хүүхэд шиг, царай өгөхгүй байх, нүүр өгөхгүй байх*

Нийлээд нэгэн тодорхой, голдуу утгыг дүрслэн илэрхийлсэн үгийн тогтвортой бүрэлдүүлбэрийг хэвшмэл хэллэг, өвөрмөц хэлц гэнэ. (Redewendung feste Verbindung von Wörtern, die zusammen eine bestimmte, meist bildliche Bedeutung haben)

Өвөрмөц хэлцийн үндэс нь ухагдахуун байдаг. Өвөрмөц хэлц хичнээн бүрэлдүүлбэртэй байлаа ч утга төгссөн санааг гаргадаггүй. “Ханан гэрээсээ холдож, хадан гэртээ ойртох” гэх зэрэг.

⁵² Орчуулагч, судлаач

Өвөрмөц хэлц нь түүхэн тодорхой үед, онцгой нөхцөл байдалд буй тодорхой мэргэжил, ажил үйлс эрхэлдэг хүмүүсийн дунд буй болоод цаг хугацааны явцад аж төрөх байдал өөрчлөгдөн анхны утга санаа нь өнөөгийн нөхцөл байдалд ойлгогдохгүй болсон тодорхой үгсийн нийлэмжийг **өвөрмөц хэлц**⁵³ хэмээн нэрлэх болж байна.

Үйлний хайрцаг гэдэг нь эмэгтэй хүний үйл урлахдаа хэрэглэдэг нарийн нандин юмны сав бөгөөд түүнд нь тэр болгон хүн хүрэхгүй тул түүндээ хувийн нууц юм аа хадгалдаг байжээ.

Үйлний хайч эмэгтэй хүний үйл урлахдаа хэрэглэдэг, өөр хүнд хэрэглүүлдэггүй хурц иртэй хайч.

Гар нийлэх хамтарч юм хийхэд ажил үйлс бүтэмжтэй байхыг хэлнэ.

Тэнгэрийн хишиг хүртэх; бусдаас илүү хувь авахыг хэлнэ.

Ханцуйдаа залбирах (Daumen drucken); аливаа зүйлийг бүтээсэй гэж сэтгэл дотроо туйлаас хүсэмжлэн залбирах,

Дээлийн нь захыг мушгих, хөгжсөөн дэмжигч, шүтэн бишрэгчийн зүгээс өөрийн дэмждэг тамирчнаа ялаасай хэмээн сэтгэлдээ дэмжих хүсэмжлэл,

Хусмаа чамласан хүүхэд шиг, оноосон хувиа чамлан урвайх, хусам гэдэг нь сүү хөөрүүлж өрөм байлгаад маргааш нь өрмөө авч, сүүгээ юүлэхэд тогооны ёроолд тогтдог сүүний наалдац, дээд талын хэсгийг цагаан хусам гэх бөгөөд түүнийг хүүхэд иднэ, доод талын түлэгдсэн хэсгийг хар хусам гэнэ. Түүнийг нохойд өгдөг.

Царай өгөхгүй байх, нүүр өгөхгүй байх, аливаа хүний хүсэл, гуйлтыг үл тоох, эс биелүүлэх, өөрийн зүгээс боломж олгохгүй байхыг хэлнэ.

Өвөрмөц хэлцийн утгыг зөв ойлгож, зөв тайлбарлаж, зөв орчуулж, дүйцүүлэхийн тулд уг хэлцийн анхдагч болон шилжсэн утгыг нарийвчлан судлах шаардлагатай ажээ. Иймд сонгон авсан өвөрмөц хэлцийн гарал үүслийг нэг бүрчлэн судалж үзлээ. Герман хүмүүсийн сэтгэлгээний онцлогийг хэлц үгийн бүрдүүлбэр дээрээс харж болох ажээ. Герман- монгол хэлцийн дүймэн⁵⁴-д орсон үгийн зарим утгын гарал үүслийг судалсны үндсэн дээр мөшигөн тайлбарлавал:

“Abends werden die Bürgersteige hochgeklappt” (Оройдоо явган хүний замыг дээш сойчихдог) хэлцийн гарал үүслийг мөшигөх аваас:

Дундад зуунд германы хөдөө тосгоны дэлгүүр, үйлчилгээний газар эрт хаах тул оройдоо гудамж, талбайгаар хүн амьтан үзэгдэхгүй. Хүмүүс гэртээ цай ууж тухлан, үлгэр ярьж, хууч хөөрч, хөзөр тоглодог байжээ. Оройдоо зам, талбай хүн, амьтангүй, ил хуль болдгийг германчууд егөөдөн “явган хүний замыг оройдоо дээш сойчихдог” юм гэгцгээнэ. Хүн амьтан гадуур гардаггүй, ил хуль байдаг гэсэн санааг илэрхийлэх ажээ.

⁵³ Эрдэмтэн, судлаачид янз бүрээр нэрлэжээ, өвөрмөц хэлц нэг үг, тогтмол тогтоц бүхий хэд хэдэн үгнээс бүрддэг тул хэлц үг гэх нь оновчтой мэт санагдана.

⁵⁴ А. Цэрэнчулууны орчуулж, Д-р Ж. Бат- Ирээдүйн хянан тохиолдуулсан герман-монгол өвөрмөц хэлцийн дүймэн "Бэлгийн морины шүдийг үздэггүй" нэртэй товхимол, Улаанбаатар хот, 2016 он

Одоогийн утга: оройдоо юу ч болдоггүй, уйтгартай газар

Монгол дүйцүүлэг: “дүлий дүмбэ оргисон газар, ил хуль газар”

“Abgebrannt sein” (хуйхлагдаж орхисон) хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Түймэрт ороод хамаг юмаа шатааж орхиод “бийгээс бие л үлдсэн” хүн байна хэмээн төсөөлөгдөнө. Үнэнийг хэлэхэд туу гэх нохой үгүй, чаа гэх ямаагүй; орох оронгүй, оочих аяагүй; гэдэс хоосон, мөр нимгэн; халаасандаа сохор зоос ч үгүй; үгээгүй нэгэн байж таараа.

Одоогийн утга: огт мөнгөгүй, юу ч үгүй хоосон

Монгол дүйцүүлэг: “модоо барьсан гуйлгачин”

“Alles für die Katz” (бүгд муурын юм болох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөвөөс:

Эрт цагт хүмүүс нэгэн дарханаар хүн юм хийлгээд зүгээр л “баярлалаа” гэхээд л юмаа аваад явчихдаг байж гэнэ. Тэр дархан нэгэн муур авчраад дэргэдээ уячихжээ. Тэгээд юм хийлгэсэн хүн “баярлалаа” -гаар хөлсөө төлөх бүр тэр “баярлалаа”-г муурандаа “Май үүнийг чамд” гэдэг өгөх дүр үзүүлдэг байжээ. Харамсалтай нь “хоосон баярлалаа хоол болдоггүй” болохоор нөгөө муур өлбөрч үхсэн гэдэг.

Үүнээс хойш хэн нэгний хичээл зүтгэл талаар болж, хийсэн ажил үр дүнгүй болж бүтэлгүйтэж орхивол “*муурны юм болох*” (хар нохойн хоол болох) хэмээх хэлцийг хэлдэг болжээ.

Одоогийн утга: хичээл зүтгэл талаар болж, хийсэн ажил үр дүнгүй болох

Монгол дүйцүүлэг: “хар нохойн хоол болох, гарын гарз, хөлийн гай; хөлсгүй ажил; хайран хөдөлмөр болох”

“Alles im grünen Bereich” (Бүгд ногоон бүсэд байна) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Суурь машин, техник бий болсон үед гарсан хэлц ажээ. Машин хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгаж үзсэн хүн хяналтын зүү ногооноор заасан хүрээнд хэлбэлзэж байгааг хараад бүх юм хэвийн, зохих ёсоороо, ном журмаараа ажиллаж байна гэдгээс гаралтай ажээ. Шилжсэн утгаараа алив юм хэвийн байх юм бол “бүгд ногоон бүсэд байна” гэдэг ажээ.

Одоогийн утга: Бүх юм хэвийн, зохих ёсоороо, ном журмаараа явж байна.

Монгол дүйцүүлэг: “ном журмаараа байна; хэвийн байна”

“Äpfel mit Birnen vergleichen” (Алимыг лийртэй адилтгах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Хоёр шал өөр төрлийн юмыг хооронд нь адилтгах, алив юмны үндсэн шинжийг орхигдуулан харьцуулшгүй хоёр зүйлийг хооронд нь адилтгах, нийцэшгүй хоёр юмыг хооронд зүйрлэх гэсэн утгатай ажээ.

Одоогийн утга: Алив юмны онцлог шинжийг орхигдуулан харьцуулшгүй хоёр зүйлийг хооронд нь адилтгах, нийцэшгүй юмыг харьцуулах

Монгол дүйцүүлэг: “тэмээг ямаатай зүйрлэх; тэнгэрийг газартай адилтгах”.

“Auf einer Wellenlänge” (Ижил суваг дээр) хэмээх хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Радио холбооноос үүдэлтэй, харилцаж, холбоо барьж байгаа хоёр хүн хоёулаа нэг суваг дээр байж байж л хоорондоо ярьж чадах билээ. Харин шилжсэн утгаараа санаа нийлэх, сонирхол таарах гэсэн утгатай ажгуу.

Одоогийн утга: Сайн ойлголцдог, санаа нийлдэг.

Монгол дүйцүүлэг: “гар нийлэх, ганзага нийлэх, ам хэлээ амархан ололцох, санаа нийлэх”.

“Auf großem Fuß leben” (Том хөл дээр амьдрах) хэмээх хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дундад зууны үед Францад Анжоу хэмээх нэр төртэй, чинээлэг нэгэн гүн аж төрдөг байж. Тэр гүн хөл дээрээ нэг уртай байсан тул тэр үеийн гоё гутлыг өмсөж чаддаггүй байсан гэнэ. Гэтэл түүнд нэгэн уран санаа төрж, нэг гуталчинд захиалга өгөн том шувууны хошуу шиг хамартай гутал хийлгэн өмсөөд санаа амар явах болсон юм гэдэг. Хавь ойрын хүмүүс бүгд л түүний том гутал өмсдөг, бийлэг цийлэг, элбэг хангалуун амьдардаг болохыг мэддэг байжээ. Тэгээд том хөлтэй, том гутал өмсдөгийг л түүний элбэг хангалуун амьдардагтай холбож ярьдаг болсон хэрэг.

Одоогийн утга: Бийлэг цийлэг, элбэг хангалуун амьдрах, үрэлгэн загнах

Монгол дүйцүүлэг: “Бийлэгжүү загнах; элбэг хангалуун амьдрах; үрэлгэн загнах; мөнгөө баруун солгойгүй цацах, баян хүн шиг бялхалзах”.

“Aufpassen wie ein Schießhund” (Анчны нохой шиг сонор соргог байх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас: Герман анчин нэг нохой дагуулж явах бөгөөд шувуу, туулай буудаад унагахаар нохой нь давхиж очоод зуугаад ирдэг билээ. Тэгээд түүндээ ангийнхаа хишиг хүртээх юм уу, илж маажиж урамшуулдаг байна.

Одоогийн утга: анхааралтай байх, тун сонор соргог байх

Монгол дүйцүүлэг: “сонор соргог; адуу шиг соргог байх;”.

“Aus allen Wolken fallen” (Бүх үүлнээс унах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Эртний грегийн Аристофанес өөрийн бичсэн нэгэн инээдмийн жүжигт “Үүлэн хөхөөний гэр” гэж нэгэн хотыг үзүүлдэг. Энэ хот үүлэн дээр оршдог бөгөөд тэр хотоос газар дэлхий дээр унасан хүн бодит байдал дээр газарддаг гэнэ.

Одоогийн утга: Гайхаж хоцрох, сэхээ авах, гэнэт бодит байдалд орох

Монгол дүйцүүлэг: “алмайрч хоцрох; сэхээ орох; бодит байдалд бууж ирэх; жинхэнэ төрхөндөө орох; нойрноосоо сэрэх; зүүднээсээ сэрэх;”.

“Aus dem letzten Loch pfeifen” (Сүүлчийн нүхээр үлээх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц лимбэ хөгжмийн зэмсэг тоглохоос үүдэлтэй ажээ. “Сүүлчийн нүхээр нь үлээх”-эд хамгийн бүдүүн дуу гардаг байна.

Одоогийн утга: Хүнд өвчтэй хэвтэрт байх, сэтгэл санаа, эд хөрөнгийн доройтолд орох, эцсийн хүчээ шавхах.

Монгол дүйцүүлэг: “тартагтаа тулах; шалдаа буух; хэвтэрт орох; эцсийн хүчээ шавхах; морио эмээллэх; сархинагаа эргэтэл ярих”.

“Aus dem Nähkästchen plaudern” (Үйлний хайрцагнаас хуучлах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас: Дээр үед германы бүсгүйчүүд хайрын захиа зэрэг нандин, нууц юмаа өөрийн өмч болох үйлний хайрцгандаа хадгалдаг байсан үеэс үүдэлтэй ажээ. Тэгээд үерхдэг бүсгүйгээ ирэхэд үйлний хайрцгаа нээн хайрын захиагаа сонирхуулж, хамаг нууцаа ярьдаг байсан хэрэг.

Одоогийн утга: Хувийн туршлагаа хуваалцах, хувийн нууцаа дэлгэх

Монгол дүйцүүлэг: “Нууцаа дэлгэх; нарийн ширийн юмаа ярих; долоон булчирхайгаа тоочих;”.

“Aus dem Schneider sein” (Арай ч оёдолчин болчхоогүй байх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц хэзрийн ертөнцөөс үүдэлтэй ажээ. Германы “скат” хэмээх хэзрийн тоглоомд авах ёстой ононыхоо талыг ч авч чадаагүй тоглогчийг “оёдолчин⁵⁵” боллоо, “шатлаа” гэдэг. Талаас илүү тоог авчихвал “оёдолчин лав болохгүй” боллоо гэнэ.

Одоогийн утга: Хүнд байдлаас гарах, түр зуурын бэрхшээлээс гарах, аятай байдалд орох

Монгол дүйцүүлэг: “Айдгаа авдрандаа хийх; даваагаа давах;”.

“Aus der Haut fahren” (Арьснаасаа гарч явах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Арьс гэдэг биеийг гадны нөлөөнөөс хамгаалдаг бүрхүүл. Дэлбэртээ уурласан хүн тэр бүрхүүлээ хаяад гарахдаа хүрнэ гэсэн егөөдөл ажээ.

Одоогийн утга: Хэт уурлах, цухалдах, биеэ барьж дийлэхээ болих, дээлэндээ багтахгүй болтол уурлах, галзуурахад ганц хуруу дутуу

Монгол дүйцүүлэг: “дээлэндээ багтахгүй болтол уурлах; дэлбэртлээ уурлах, галзуурахад ганц хуруу дутуу; биеэ барьж дийлэхгүй болох”.

“Aus einer Mücke einen Elefanten machen” (Шумуулыг заан болгох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас: Аль ч ард түмэнд ялих, шалихгүй юмыг хэт дөвийлгөн, туулайн чинээ юмыг уулын чинээ болгон сүржигнэдэг хүмүүс байх л. Тэгээд үндэстэн бүхэн өөр өөрөөр сэтгэдэг, зүйрлүүлж, харьцуулдаг ажээ. Шумуул бол ус чийгтэй газар бүхэнд байдаг. Харин заан бол орон бүхэнд байдаггүй. Магадгүй энэ хэлц энэтхэг, африк тивээс гаралтай ч байж болох юм.

Одоогийн утга: Аливаа юмыг байгаагаас нь хэт дөвийлгөх, шалихгүй зүйлд тун ч их сүржигнэх, хэтрүүлэх, дэгсдүүлэх

⁵⁵ Германчууд оёдолчныг хамгийн ядуу хүмүүс гэдэг. Германы хэлний нэг хэлцэд “оёдолчин л биш бол ор ор!” гэж байдгийг бодоход хүмүүс юм оёулаад “луу унжин” хөлсөө төлж өгөхгүй зовоодог байсан тул оёдолчид ядуу амьдралтай байсан байж болох талтай.

Монгол дүйцүүлэг: “Батганын чинээ юмыг барын чинээ болгох; туулайн чинээ юмыг уулын чинээ болгох, хий сүржигнэх”.

“Außer Rand und Band sein” (Бүслүүр, боолтгүй болох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Торх, суулга хийдэг мужаан ярианаас гаралтай ажээ. Хэрэв торхны бүслүүр нь мултарчихвал торхны мод тарж унана. Бэлдэц модны баглаа тасарч орхивол бас тарж бутарна. Үүнийг шилжсэн утгаар авч хэрэглэсэн хэлц юм байна.

Одоогийн утга: Хяналтаас гарах, баярлан цовхчих, хөөрч баясах

Монгол дүйцүүлэг: “Дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэх; булуу нь халах”.

“Bahnhof verstehen” (галт тэрэгний буудал л ойлгох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц дэлхийн I дайны үеэс үүдэлтэй ажээ. Цэргүүд дайн тулаанаас залхаж гүйцээд зөвхөн гэртээ харихаас өөр зүйл бодохгүй байсан үе. Галт тэргэнд суугаад шалавхан харих гэсэн ганц бодол л цэрэг бүхний толгойд нь эргэлдэж, өдрийн бодол шөнийн зүүд болж байжээ. Тэгээд ямар ч тушаал өгсөн галт тэрэгний буудал л санаанд нь ордог, ганц боддог юм нь “галт тэрэгний буудал” л болжээ. Толгойд нь өртөөний буудлаас өөр юм бодогдохоо больсон гэсэн үг.

Одоогийн утга: ойлгохгүй, ухаан хүрэхгүй, юу гэсний учрыг эс ойлгох

Монгол дүйцүүлэг: “ойлгохгүй юм, хальтлахгүй юм, барахгүй юм, мэдэхгүй юм.”.

“Bei jemandem abgemeldet sein” (хэн нэгний санамжаас хасагдаж орхих) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас: Хэн нэгэнд гомдоод ч юм уу, түүнийг тоохоо больсон тохиолдолд яаж ч мэрийгээд зүтгээд сэтгэлийг нь татах горьдлогогүй болдгоос гаралтай.

Одоогийн утга: хэн нэгнийг хэдийн анхаарахаа больж, санаа тавихгүй болох.

Монгол дүйцүүлэг: “тогос шиг гоёод, алтан гургалдай шиг донгодоод ч нэмэргүй”.

“Bekannt wie ein bunter Hund” (Алаг нохой шиг танил) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хэн нэгэн тун онцгой, содон бол “алаг нохой шиг содон” гэдэг хэлцийг хэрэглэдэг. Ноход уул нь нэг өнгөтэй байдаг бол хоёр өнгөтэй алаг нохой тун содон билээ. Анхны утга нь тааруухан шинжийг илтгэдэг байсан бол эдүгээ хамгийн сайн найздаа ч санаа зоволтгүй хэлдэг хэлц болжээ.

Одоогийн утга: олны танил хүн, од болсон хүн, содон сондгой

Монгол дүйцүүлэг: “Олны танил хүн; тэмээнээс тэмдэгтэй; ямаанаас янзтай, олноос онцгой”.

“Beleidigte Leberwurst” (Гомдсон элгэн хиам) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц хиамны үйлдвэрээс гаралтай бөгөөд элгэн хиам тогоотой усанд буцлаад уурандаа дэлбэрч задардаг, хиам хийж байгаа хүмүүс амархан болдог цусан хиам зэргийг эхэлж аваад байхаар тогоонд ганцаараа үлдсэн элгэн хиам гомддог байх гэсэн ярианаас үүдэлтэй.

Одоогийн утга: урвайсан, гомдсон, уруу царайлсан,

Монгол дүйцүүлэг: “Хусмаа чамласан хүүхэд шиг, урвайж хоцорсон”.

“Bis in die Puppen” (Хүүхэлдэйнүүд хүртэл) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Берлингийн “Tiergarten”(Амьтны хүрээлэн)-д “Долоон бурхан” хэмээх нэгэн талбай байдаг байжээ. XVIII зууны үед тэнд байсан олон баримлыг хүмүүс “хүүхэлдэйнүүд” гэдэг байжээ. Амьтны хүрээлэнгийн тэг дунд байх “хүүхэлдэйнүүд” хүрэхэд нэлээд удаж хүрдэг байжээ. Тэнд очоод ирэхэд ихэнхдээ оройтдог байсан тул орой болтол битгий яваарай гэхийг “хүүхэлдэйнүүд хүртэл”явахгүй шүү хэмээх хэлц үг гарчээ.

Одоогийн утга: Тун удаан, шөнө дөл болтол, тун хол

Монгол дүйцүүлэг: “Орой болтол, од түгтэл, шөнө дөл болтол”.

“Bis zum Abwinken” (больё гэтэл) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Ирсэн зочныг хоол, цай болон дайлах сайхан ч больё гэтэл нь хоолоор шахах бас хэцүү. Энэ хэлцэнд больё, байя гэтэл хоол, ундаар шахахыг хэлжээ.

Одоогийн утга: хүрэлцээтэй, их хэмжээтэй, цадаж ханатал

Монгол дүйцүүлэг: “амаар гартал идэх; гэдсээ хагартал идэх, цүдийтэл идэх”.

“Blau machen” (Хөх болгох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Хөх болгох” гэдэг хэлц “хөх даваа гараг” гэдгээс гаралтай ажээ. Хөх даваа гарагт ноос ээрэх будах үйлдвэрийн ажилчид ням гарагт ноосоо будганд оруулаад даваа гарагт будаг орохлоор нь авч задгай газар тавин хатахыг нь хүлээн амардаг байжээ. Тэр үед хэрэглэж байсан будаг нь агаарт химийн урвалд ороод хөх болдог байсантай холбоотой аж.

Одоогийн утга: ажил таслах, хичээл таслах, онцын шалтгаангүйгээр очихгүй байх, чөлөөгүй таслах

Монгол дүйцүүлэг: “ажил таслах; хичээл пялах”.

“Blau es Blut in den Adern haben” (Судсандаа хөх цустай) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хөх цустай, тайж гаралтай хүн гэсэн үг. Тайж гаралтай хүн гадаа гандаж, хөдөө хөхөрч ажиллах шаардлагагүй тул цонхигор цагаан арьсны цаанаас судас нь хөхөрч харагддагаас “хөх цустай” гэдэг хэлц үг гарчээ.

Одоогийн утга: тайж гаралтай, дээгүүр заяатай

Монгол дүйцүүлэг: “Цагаан ястан; язгууртан”

“Auf die Tube drücken” (шахуурга дээр дарах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц үг автомашин гарсан үетэй холбоотой аж. Машинаа хурдан явуулахын тул хий нэмж өгөх, өөрөөр хэлбэл хааз нэмэх, “гишгээд өгөөч” гэсэнтэй утга нэгэн билээ.

Одоогийн утга: Хурдлах, яаравчлах

Монгол дүйцүүлэг: “Хаазлах; гишгэх; дөрөө жийж; жолоог тавих; жолоо сунгах; гялалзах; хурдаа нэмэх”.

“Butter bei die Fische geben” (Загасан дээр цөцгийн тос хийх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Загасыг шарж, жигнээд зоогийн ширээн дээр тавихын өмнөхөн дээр нь цөцгийн тос хийдэг байснаас гаралтай ажээ. Тэгэхдээ яг идэхийн өмнө л тос хийнэ. Цөцгийн тос хийнгүүтээ идэх хэрэгтэй ажээ.

Одоогийн утга: Шуудхан хэлэх, үнэнийг хэлэх, хөрөнгө оруулах, ажил хэрэгтээ орох, гол зүйлээ эхлэх

Монгол дүйцүүлэг: “ямааны мах халуун дээрээ, цагаа олж хөдлөх, хөрөнгө оруулах; асуудалдаа орох; ажлаа барьж авах; гол юмаа хийх”.

“Da beißt die Maus keinen Faden ab” (хулгана ямар ч утас тас хазахгүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Арслан хулгана хоёрын тухай Аесопын ёгт үлгэрээс үүдэлтэй ажээ. Уг үлгэрт арсланг хүлсэн дээсийг хулгана тас мэрг өгч арсланг авардаг.

Одоогийн утга: Ийм л байх болно, өөрчлөх аргагүй, ямар ч авралгүй

Монгол дүйцүүлэг: “авралгүй, өршөөлгүй, мадаггүй; гарцаагүй”.

“Da brat mir einer einen Storch” (над дэглий шарж байна уу гэлтэй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Германы домгоор дэглий айл гэрт аз жаргал, үр хүүхэд авчирдаг ажээ. Хуучин гэрээслэлээр дэглий алж идэхийг хориглодог байна. Тэр ч байтугай дээвэр дээр дэглий үүрлэвэл үргээдэггүй. Дэглий шарах гэдэг тэгэхлээр үнэмшмээргүй, байж болшгүй зүйл.

Одоогийн утга: Гайхаж орхих, цочирдон уулга алдах, уурлаж цухалдахад хэлдэг үг.

Монгол дүйцүүлэг: “үзээгүй юмаа үзэж, үхэр цам харайхыг харах”.

“Da haben wir den Salat” (яг салат болж орхилоо) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Герман хэлний “Салат” гэдэг амттай сайхан хачир гэдэг утгатай бол “салат болох” гэдэг нь юм юм хольж хутгасан тааруухан юмыг хэлдэг байна. Хийсэн ажил эмх замбараагүй болж, бүтэлгүйтэх, авралгүй болохыг бас ингэж хэлнэ.

Одоогийн утга: Алив юм бүтэлгүй, үр дүнгүй болох

Монгол дүйцүүлэг: “Холион бантан болох; жонхуу болох”.

“Da ist der Bär los” (тэнд баавгай алдуурч орхижээ) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дээр үед хот, тосгонд ямар нэг баяр ёслол болбол явуулын циркчид ирж, сургуультай баавгай тоглуулдаг байжээ. Тийм учраас аль нэг газар их хөгжиж цэнгэж байвал ёстой нэг “баавгай бүжиглэж байна” гэдэг болжээ.

Одоогийн утга: Тэнд ч ёстой юм юм гэгч болж байна, баярлаж гарч байна, наадам ид дундаа явж байна.

Монгол дүйцүүлэг: “булуу нь халж байна; ид дундаа явж байна”.

“Da kann ich dir ein Lied von singen” (Энэ талаар ч харин нэг дуу дуулж өгч чадна шүү) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

XVI зууны үед герман хэлний “Lied” (дуу) гэдэг үг “лекц” гэсэн утгатай байжээ. Хүсвэл хүн лекцээ аялгуулан уншдаг байсан байна. Бүр сүүлд шүлгэнд ая зохион дуулдаг болсноор орчин үеийн бидний дуу гэдэг ойлгоц буй болжухуй. Хашир суусан хүн өнгөрсөн амьдрал, туулж ирсэн явдлынхаа талаар нэг лекц унших хэмжээний мэдлэгтэй болсныг “нэг дуу дуулж чадахуйц” гэдэг байжээ.

Одоогийн утга: туулж, өнгөрүүлсэн туршлагаасаа харин ч нэг өгүүлж дуулна даа

Монгол дүйцүүлэг: “багагүй туршлагатай, бараг лекц уншсан ч чадна; жор мэдэхгүй эмчээс зовлон үзсэн жавганц дээр”.

“Da lachen ja die Hühner” (үүнд чинь тахиа хүртэл инээнэ) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Германчууд тахиаг хамгийн тэнэг амьтан гэгцгээдэг. Хамгийн тэнэг амьтан тахиа хүртэл шоолон инээж байвал тэр юм үнэхээр утгагүй, инээдтэй юм байж таараа. Наадахыг ч сонссон тахиа хүртэл инээдээ барах болно гэсэн ёгт утгатай.

Одоогийн утга: шал инээдтэй хачин юм, үнэмших аргагүй юм

Монгол дүйцүүлэг: “Шал инээдтэй юм, тэнэг юм”.

“Da liegt der Hase im Pfeffer” (туулайн перцээр амталсан мах байна) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

XIII зууны үед туулайн махыг жижиглэж хэрчээд перцээр амтлан бусад амьтны махтай холин үдийн хоолонд тавьдаг байжээ. Перцийн хурц үнэрээс болоод чухам ямар амьтны мах болохыг ялгаж мэдэхэд бэрх болдог байна. Шилжсэн утгаараа ямар нэг асуудлын үнэн учрыг олоход яг л энэ туулайн махтай адил хэцүү байдаг.

Одоогийн утга: Энэ шийдвэрлэх, гол зүйл, гол шалтгаалах зүйл, гол уршиг нь энэ байна

Монгол дүйцүүлэг: “Юмны учир, сумны гичир; муу бүхний хамаг уршиг”.

“Da wird der Hund in der Pfanne verrückt” (Тэр тогоон доторх нохой галзуурах нь ээ) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Ойленшпиегель нэг удаа айлын шар айрагны үйлдвэрт ажиллаж байхад тэднийх “зөрөг” гэж нэг нохойтой байжээ. Эзэн нь нэг удаа шар айргаа хийхдээ “зөрөг” –өө хийгээд анхааралтай буцалгаж байгаарай гэжээ. Мань эр “зөрөг”

гэдэг нохойг нь аваад тогоотой усанд хийж орхижээ. Түүнээсээ болж Ойленшпиегель ажлаасаа хөөгдсөн гэдэг.

Одоогийн утга: хачин юм болох, гайхал төрүүлсэн, үнэмших аргагүй зүйл болох, үнэмшмээргүй юм болох

Монгол дүйцүүлэг: “Ангайж хоцрох; мэл гайхаж цэл хөхрөх.

“Damoklesschwert” (Дамоклесийн илд) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Эртний нэгэн үлгэрт: Сиракус хааны зарц Дамоклес гэж байжээ. Хаан нь түүнийг ертөнцийн хамгийн аз жаргалтай хүн хэмээн магтдагт тэр туйлын сэтгэл хангалуун байсан гэдэг. Тэр ч бүү хэл хаан нь түүнд хаан ширээгээ шилжүүлэх бодолтой байж. Харин хаан ширээнд суулгахын өмнө нэгэн хүнд гэгчийн илдийг адууны сүүлний ганц хялгасаар оосорлон суудал дээр нь зүүжээ. Хэзээ хялгас тасран илд толгой дээр нь унахыг хэн ч тааварлаж эс мэднэ. Сиракус аз жаргал удаан үргэлжилдэггүй, алхам тутамд золгүй явдал дагаж байдаг гэдгийг мэдүүлэх гэж ийм нэгэн зүйл хийжээ. Эдүгээ ч гэсэн хүмүүсийн толгой дээр Дамоклесийн илд савлаж байдаг бус уу.

Одоогийн утга: алхам тутамд аюул занал хийлж байдаг,

Гай газар доороос гарч ирдэг.

Монгол дүйцүүлэг: “Амь дүйсэн; айдас төрүүлсэн; гай газар дороос, гахай модон дотроос”.

“Danach kräht kein Hahn” (Тахиа ч тоож донгодохгүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Германчууд тахиаг хамгийн тэнэг амьтан гэгцээдэг. Тэгээд тэр амьтан ч тоож дуугарахгүй, донгодохгүй, огтын үнэ, цэнэгүй юм гэсэн утгатай ажээ.

Одоогийн утга: улиг болсон, хуучирч, мартагдсан зүйл

Монгол дүйцүүлэг: “Хүн тоож, нохой шиншихгүй юм; улиг болсон юм; аль амбасын үеийн юм”

“Das A und O” (Энэ бол А, О хоёр) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“А болон О” нь герег цагаан толгойн эхний үсэг Альпа болон төгсгөлийн үсэг Омега. Алив юмыг сайн эхэлж, амжилттай төгсгөх явдал бол хамгаас чухал. Хамгийн чухал зүйл, гол юм гэсэн санааг илэрхийлнэ.

Одоогийн утга: Амин сүнс нь, хамгийн гол нь

Монгол дүйцүүлэг: “амин сүнс; эхлэл төгсгөл хоёр; гараа бариа хоёр”.

“Das Ei des Kolumbus” (Колумбусын өндөг) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэхүү домгоор бол Кристоф Колумбус америк тивийг нээж ирээд нэгэн том хүлээн авалтад уригджээ. Халамцаж согтсон нэг эр америк тивийг нээх гэдэг тийм ч онцгой зүйл биш гэжээ. Түүнд Колумбус ихэд цухалдан суудлаасаа босож ирэн нэг чанасан өндөг аваад та нарын хэн нь энэ өндгийг зууван талаар нь ширээн дээр тогтоох вэ гэсэнд бүгд гайхан мөрөө хавчсан гэдэг. Колумбус

өндгийг авч зууван талыг нь цохиж хальсыг бяцлаад ширээн дээр тогтоочоод сэтгэл хангалуунаар ширээндээ эргэн суусан гэдэг. Энэ тухай Гироламо Бензони 1565 онд “Шинэ дэлхийн түүх” гэдэг номдоо бичсэн ажгуу.

Одоогийн утга: Тун амархан, санаанд оромгүй амархан шийдэл

Монгол дүйцүүлэг: “алга урвуулах шиг амархан; Санаанд оромгүй амархан зүйл”.

“Das geht auf keine Kuhhaut” (Энэ бол ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Европод цаас хэрэглэж сураагүй байхад фергамент хэмээх үхрийн адсага, ямааны турсгаар хийсэн самбар дээр юм бичдэг байжээ. Нэг хүний насан туршдаа үйлдсэн нүглийг чөтгөр нэг фергамент дээр бичдэг хэмээн ярьдаг байжээ.

Одоогийн утга: хэрээс хэтэрсэн, хүлцэшгүй, зөвшөөршгүй, ичгүүргүй, үнэмшмээргүй юм.

Монгол дүйцүүлэг: “хэрээс хэтэрсэн, хүлцэшгүй, ичгүүргүй, үнэмших аргагүй”.

“Das Gelbe vom Ei ” (Өндөгний шар) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Өндөгний шар” гэдэг нь байх ёстой хэмжээнд хүрсэн гэсэн үг. Нүдэлж шарсан, чанасан ямар ч өндөгний гол амттай, чанартай хэсэг нь өндөгний шар билээ.

Одоогийн утга: шим шүлт, гол зүйл, хамгийн ашигтай юм (биш)

Монгол дүйцүүлэг: “Охь шим (биш); шим шүлт (биш)”.

“Das Gras wachsen hören ” (Өвс ургах чимээг сонсох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Яльгүй юмыг ч гэсэн өөрчлөгдөхийг эс андах гярхай, гэсэн үг.

Одоогийн утга: Маш сонор соргог; юм бүхнийг анддаггүй, алив болох юмыг гадарладаг, болоогүй юманд их санаа зовдог, сэтгэлийн хөөрөл ихтэй, их аймхай, болгоомжтой

Монгол дүйцүүлэг: “өвс хөдлөхийг андахгүй; гутал дотор хөлийн хуруу хөдлөхийг андахгүй; сэтгэлийн хөөрөлтэй; эмзэг сэтгэлтэй; дэндүү мэдрэмтгий; уяхан сэтгэлтэй”.

“Das Handtuch werfen” (Гарын арчуураа шидэж орхих) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Бокс тоглож байгаа хүн гарын арчуураа шидэх гэдэг нь тэмцээнийг дуусгах гэсэн үг болой. Алив зүйлд бууж өгөхөөс өөр аргагүй болсон тохиолдолд энэ хэлцийг хэлнэ.

Одоогийн утга: Болих, бууж өгөх, ажлаас гарах, цөхрөнгөө барах

Монгол дүйцүүлэг: “Бууж өгөх; болих; ажлаас гарах; зайгаа тавьж өгөх”.

“Das hast du dir selbst eingebrockt” (Чи өөрөө л хөшиглөж хийсэн шүү дээ) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Германд тарчиг ядуу амьдралтай айлын хүмүүс шөлөндөө талх бутлан хийж арвижуулан иддэг байжээ. Зарим нь буталж хийсэн талхаа барахгүй орхидог байжээ. Тийм тохиолдолд өөрөө хийсэн юмаа өөрөө л идэх болж дээ гэнэ.

Одоогийн утга: Будлиан хутгаж, буруу юм хийсэн хүн өөрөө л тэр бүхнээ цайруулж, хэвэнд нь оруулах хэрэгтэй

Монгол дүйцүүлэг: “Өөрөө хийсэн лайгаа өөрөө эдлэх; хийсэн нүглээ өөрөө цайруулах ёстой”.

“Das interessiert kein Aas” (Хэн ч сонирхохгүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Аас” гэж германаар сэг зэмийг хэлэх боловч энд “адгийн амьтан” гэсэн утгаар оржээ. Адгийн амьтан ч тоохгүй гэсэн утгатай.

Одоогийн утга: дорд үзсэн, үл тоосны илэрхийлэл

Монгол дүйцүүлэг: “Хүн тоож, нохой шиншихгүй юм”.

“Das ist doch zum Mäusemelken!” (ёстой нэг хулгана саамар!) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Үнэнийг хэлэхэд хэрвээ хулганыг саадаг сан бол ёстой нэг там идсэн, галзуурмаар юм байж таараа.

Одоогийн утга: уур хүрмээр, галзуурмаар, там идсэн, огт үр дүнгүй, бүтэшгүй юм

Монгол дүйцүүлэг: “Уур хүрмээр, солиормоор, там идсэн ажил”.

“Das ist Jacke wie Hose” (хүрэм, өмд ялгаагүй адил) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Хүрэм, өмд хоёр андуурмааргүй ялгаатай ч хийж байгаа хүний хувьд бол нилээд зүйл нь төстэй, нэг нь хоёр шуумагтай бол, нөгөө нь хоёр ханцуйтай, хоёулаа адилхан материал ордог ажээ. Алийг нь ч хийсэн адилхан гэсэн утгатай“ хүрэм, өмд ялгаагүй” гэсэн хэлц үг гарчээ.

Одоогийн утга: Адилхан, ялгаагүй, миний хувьд бол ав адилхан, аль нь ч яахав

Монгол дүйцүүлэг: “Адилдаа адил, годилдоо годил; аль нь ч яахав; дүндээ дүн, бандаа бан”.

“Das ist Kokolores” (Энэ ч тахиа донгодохтой адил) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Коколкорес” гэдэг нь тахиа дуугарахтай адил чалчаа үг, хоосон бардамнал гэсэн утгатай. Тахианы дууг “Күкелдрес” - “Коколкорес” - “кикерики” хэмээн өөр өөрөөр тэмдэглэж иржээ. Тахианы дуу авиа өөрчлөгдөөгүй ч хүн өөр өөрөөр мэдрэх болсон хэрэг.

Одоогийн утга: чалчаа үг, дэмий яриа

Монгол дүйцүүлэг: “зайдан үг; зуйгуул үг; чалчаа үг”.

“Das ist mir Schnuppe!” (Энэ чинь надад дэнгийн голын бадамтай адил!) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дэнгийн голын бадам их ч бай, бага ч бай хүнд хүртээлгүй зүйл.

Одоогийн утга: Тун ч падгүй хэрэг, хамаагүй хэрэг.

Монгол дүйцүүлэг: “Надад хамаагүй, хаданд чимээгүй; чамд хамаагүй, чихэнд хүртээлгүй”.

“Das kann kein Schwein lesen!” (Үүнийг чинь ямар ч гахай уншиж дөнгөхгүй!) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дээр үед хүн бүхэн уншиж, бичиж чадахгүй байхад **Свин (Гахай)** гэж нэг бичиг, номтой хүн байжээ. Тэр хүн хавь ойрын хүний захиаг дуудаж өгдөг байжээ. Германы хойд талаар орших нутгийнхны “платтдойч” аялгаар **Свин** гэдэг нь германы **“Швайн”(гахай)** гэсэн үг юм. Огт гаргацгүй бичсэн зүйлийг ёстой нэг **“Гахай ч уншиж чадахгүй”** юм байна гэсэн хэлц гарчээ.

Одоогийн утга: Гаргацгүй, хорхойн мөр шиг бичиг

Монгол дүйцүүлэг: “Хорхойн мөр шиг гаргацгүй бичиг; хол явбал хүн гаргахгүй, хоёр хоноод өөрөө гаргахгүй”.

“Das Kind mit dem Bade ausschütten” (Хүүхдээ угаадастай нь асгах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Алив зөв юм хийгээд маш буруугаар төгсгөх. Юмыг хам хумхан, хайнгуутхан хийдэг, тэгсэн ингэсэн болгож оромддог хүнийг германчууд хошин өнгө аясаар “хүүхдээ угаадастай нь асгах” гэдэг. Түүнээс биш мангар мангар гэхэд хүүхдээ авахаа мартаад угаасан устай нь цацаж орхидог хүн ховор биз ээ.

Одоогийн утга: Хэтрүүлэх, хэт яаравчлах, зорилгоо хэтрүүлэх, хэрэгтэй юмаа хэрэггүй юмтайгаа хаях

Монгол дүйцүүлэг: “Сайн хийгээд саар төгсгөх; үхрийн сүүлэн дээр хутгаа хугалах; алдыг аваад дэлэм дээр нь, хөндийг өнгөрөөд даваан дээр нь”.

“Das kommt mir spanisch vor” (Испани хэлээр л юм шиг байна) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Ямар нэгэн ойлгомжгүй юмыг германчууд “испани хэл шиг юм” гэцгээдэг. Энэ хэлц V Карл хаан 1516 онд Испанийн хаан, 1519 оноос Германы хаан ширээнд суусан үеэс үүдэлтэй ажээ. Тэр хаан нилээд хэдэн шинэ зүйл нэвтрүүлсэн гэнэ. Хааны ордонд испани хэлийг “lingua franca” худалдаа, харилцааны хэл болгожээ. Олон янзын хэлээр ярьдаг ард түмний дунд харилцан ойлголцлыг хялбаршуулахын тулд нэг хэлийг албан ёсны хэл болгон хэрэглэхийг хэлнэ.

Одоогийн утга: Хачин, сонин, гайхалтай

Монгол дүйцүүлэг: “Ойлгомжгүй; сэжигтэй; хачирхалтай; жигтэй”.

“Das schlägt dem Fass den Boden aus” (Энэ чинь ёстой торхны ёроолыг мулт цохиж байна.) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Гэнэт цочирдон балмагдахад “ёстой л торхны ёроол мулт цохих шиг” боллоо гэнэ. Энэ нь 1516 онд шар айргийг зөвхөн зөрөг цэцэг, соёолжоор хийж байх тухай “цэвэр байлгах хууль” гарсантай холбоотой. Хэн өөр юмаар шар айраг

хийнэ. Түүнийг торгоод торхных нь ёроолыг мулт цохидог байжээ. Германчууд хуурамч, чанаргүй бараа хийсэн хүнтэй хатуу тэмцэж байсан байна шүү. Ийнхүү “торхны ёроол мулт цохих” гэсэн хэлц үг бий болжээ.

Одоогийн утга: Дэндүү юм, хэтэрч байна, ичгүүргүй юм, дуулиант хэрэг

Монгол дүйцүүлэг: “баллаж тавих; хэтрүүлж орхих; ичгүүргүй загнах; дуулиан тарих”.

“Das Zünglein an der Waage” (Жинлүүрийн хэл) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Жинлүүрийн хэл” гэдэг нь дээр үеийн хоёр тавагтай жинлүүрийн хоёр тавагны үзүүрт тавагнууд тэнцэж байгаа эсэхийг заадаг жижигхэн хоёр шувууны хошуу хэлбэртэй сум. Эсвэл гар жинлүүрийн жингийн тоог заадаг сум байсан.

Одоогийн утга: Харахад шальгүй ч гэсэн голлох үүрэгтэй зүйл

Монгол дүйцүүлэг: “Харахад бага ч хамаарал ихтэй; бие нь жижиг ч бэлчээр нь том; басаж болохгүй”.

“Daumen drücken” (Эрхий хуруугаа дарах, атгах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Эрхий хуруу бусад хуруунуудаасаа хүчтэй, таван хуруунуудаас ганцаараа бусад бүх хуруутайгаа харьцаж, дарж чадна. Эрхий хурууг аз жаргалын хуруу гэнэ. Эрхий хуруу байгалиас заяасан ер бусын их хүчтэй одой хүнийг төлөөлөх тул муу зүүднээс хамгаалдаг, хүний хүслийг биелүүлдэг хэмээн шүтэж, биширч иржээ. Алив сайн юмыг биелээсэй гэж залбирахдаа германчууд эрхий хуруугаа чанга атгана.

Одоогийн утга: Амжилт хүсэх, алив зүйл бүтэхийг хүсэх, азтай байхыг хүсэх

Монгол дүйцүүлэг: “ханцуйдаа залбирах; дээлийн нь захыг мушгих”.

“Dem Affen Zucker geben” (Сармагчинд чихэр өгөх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Сээтэгнүүр занг өдөх, хамгийн дуртай зүйлийг нь ярих; сайхан хөгжих, онгирч хөөрөх

Одоогийн утга: Амжилт хүсэх, алив зүйл бүтэхийг хүсэх, азтай байхыг хүсэх

Монгол дүйцүүлэг: “Хөөргөх; дэвэргэх; явуулах; загатнасан газар нь маажих”.

“Dem Fuchs hängen die Trauben zu hoch” (Үнэгний хувьд усан үзэм дэндүү дээр өлгөөстэй байна.) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Герегийн яруу найрагч Эсоп нийтийн тооллын өмнөх 600 онд нэг ёгт үлгэр бичжээ. Энэ үлгэрт нэг үнэг усан үзмийн хэцнээс гоё усан үзэм авч идэх гэж хэд үсрээд хүрэхгүй болохоороо “түүхий усан үзмэнд би дургүй” гэсэн гэдэг. Түүнээс хойш хэн нэгэн хүсээд хүч хүрч, авч чадахгүй юмаа, би хүсэхгүй байна гэдэг болсон гэдэг.

Одоогийн утга: Биелэх боломжгүй хүсэл, мөрөөдөл

Монгол дүйцүүлэг: “санаа байвч сачий хүрэхгүй; санаа нь сансарт, салтаа нь газарт”.

“Den Bock zum Gärtner machen” (Ухныг цэцэрлэгч болгох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Ухныг цэцэрлэгч болгох” гэдэг нь хэн нэгэнд тун тохирохгүй ажил үүрэг хариуцуулахыг хэлдэг байна. Сайжруулах бүү хэл шал дордуулах хүнийг хэлнэ.

Одоогийн утга: хэн нэгэн гарал үүсэл, сонирхлын хувьд огт тохирохгүй хүнд ажил хариуцуулах

Монгол дүйцүүлэг: “Ухныг цэцэрлэгчээр тавих; Чоноор хотоо мануулах”.

“Den Faden verlieren” (Утсаа гээх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Герегийн үлгэрийн ертөнцийн нэгэн сайхан үлгэрээс үүдэлтэй гэнэ. Энэ үлгэрт Крета арал дээрх Минос ноёны охин Ариадне Тесеаст хүүд туйлаас хайртай болжээ. Тэр нь ч бас охинд сэтгэлтэй байжээ. Гэтэл охины эцэг Лабиринт хонгилд орших “бух толгойт мангас”-ыг дараад ирсэн хүнд охиноо гэргий болгон өгнө хэмээн зар тараажээ. Тэр мангасыг дарах гэдэг амь дүйсэн хэрэг бөгөөд дарчхаад тэр хонгилын амыг олж гарах гэдэг хоёр дахь том даваа байсан гэнэ. Ухаант охин Ариадне нэгэн уран санаа сэтгэж, улаан ноосон утсан бөмбөлөг өгөөд явуулжээ. Хайртай хүн хонгилын амаар орохдоо утасныхаа үзүүрээс бариад утсаа хөвөөд явжээ. Тэсеас дэр утсаа алдалгүй дагаж яваад төөрөлгүй нүхнийхээ амыг амархан олоод гарч иржээ.

Одоогийн утга: Ярьж байснаа гацах, юу хэлэх гэснээ мартах, үгээ таслах

Монгол дүйцүүлэг: “гацаж орхих; мартагнах; толгойд орж ирэхээ болих”.

“den Kopf aus dem Sand ziehen/nehmen” (Толгойгоо элснээс гаргах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дайсан тулгарахад тэмээн хяруул хошуугаа газарт тулган зогсоход бие нь яг л нэг бут шиг харагддаг байна. Энэ нь орчинтой зохилдон биеэ хамгаалах шалгарсан арга ажээ. Үүнийг шооч хүмүүс хараад тэнэг тэмээн хяруул айхлаараа толгойгоо элсэнд шургуулаад өөрөө харахгүй болохоор амьтан харахгүй гэж боддог хэмээн ёгтолдог ажгуу.

Одоогийн утга: Алив бэрхшээл, бодит байдлын учрыг олохын оронд хүлцэнгүй хүлээн авах

Монгол дүйцүүлэг: “учрыг нь олж хужрыг нь тунгаах(-гүй байх)”.

“Den Kürzeren ziehen” (Богиныг нь сугалах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дээр үед алив эргэлзээтэй юмыг шийдэхдээ урт, богино хоёр мод атгаад нэгийг нь сугалуулна, уртыг авсан нь хожно. Богиныг авсан нь хожигдоно. Ийнхүү шодуулж шийдүүлэх нь хамгийн зөв маргаангүй шийдэл болдог байсан аж.

Одоогийн утга: Хожигдох, азгүйдэх, алдагдал хүлээх

Монгол дүйцүүлэг: “Аз дутах; хожигдох; хохирол амсах”.

“Den Löwenanteil bekommen” (Арслангийн хувь авах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Олон хүнд юм хуваахад хамгийн их, хамгийн сайныг нь авахыг “арслангийн хувь хүртэх” гэнэ. Ёлт үлгэрт гардгаар арслангийн хувийг хамгийн хүчтэй, хамгийн чадалтай нь буюу араатны хаан арслан авдаг байна.

Одоогийн утга: Хамгийн том буюу хамгийн ихийг авах,

Монгол дүйцүүлэг: “тэнгэрийн хишиг хүртэх; тэнгэрийн умдаг атгах”.

“Den Nagel auf den Kopf treffen” (Хадаасны толгойг онох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Оносон, тохирсон хариу өгөх, шалгалтын асуултад яв цав хариулахыг

“Хадаасны толгой онох” гэдэг хэлц гарчээ.

Одоогийн утга: Зөв хариу өгөх, яв цав хариулах, бодит байдлыг зөв тайлбарлах, үйл явдлыг оновчтой тайлбарлах, орой руу нь ортол хэлэх

Монгол дүйцүүлэг: “Онож хэлэх, орой руу нь ортол хэлэх, оносон хариу өгөх”.

“Den Stab über jemanden brechen” (Хэн нэгний дээр саваа мод хугалах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Шүүгч шүүхийн хурал эхлэхэд нэг саваа мод гартаа аваад хурал дуусахад буцаан тавьдаг байв. Хэрэв цаазаар авах ял оноовол саваагаа ялтны толгой дээр хугалдаг байжээ. Тэгээд “би чамд тусалж чадахгүй боллоо. Бурхан чамд туслах болно” гэдэг байжээ.

Одоогийн утга: Яллах, зүхэх, барагтайхан үнэлэх

Монгол дүйцүүлэг: “шийтгэх, зүхэх, дорд үзэх”.

“Den Teufel an die Wand malen” (ханан дээр чөтгөр зурах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Аюул занал учирна, айхтар юм болно хэмээн яривал за чи битгий муу ёрлоод бай, “чөтгөр ханан дээр зурах” хэрэггүй шүү гэдэг. Хэн нэгэн хүн чөтгөр зурах юм уу, чөтгөрийн зураг хадгалж байх юм бол чөтгөр дуудаж, муу ёрлосон хэрэг болдог байна.

Одоогийн утга: Хамгийн муу юм болох вий гэж айх, таагүй юм зөгнөх, хэт гутранг байх

Монгол дүйцүүлэг: “Муу ёрлох; муу совин татах; гутранги байх”.

“Den Wald vor lauter Bäumen nicht sehen” (Олон модонд толгой эргээд ойг эс анзаарах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Илт олон хариунд толгой эргээд оносон хариуг сонгож эс чадах. Германы нэртэй яруу найрагч, орчуулагч Кристоф Мартин Виеландын (1733-1813) зохиолоос энэ хэлц эхтэй.

Одоогийн утга: Харваас илт юмыг эс анзаарах, асуудлыг шийдэх арга нь хамар доор нь байхад эс анзаарах, хэт олон юм дуулаад толгой эргэх

Монгол дүйцүүлэг: “Хамар доорхоо харахгүй өнгөрөх; дээгүүр хараад дэргэдүүр нь үзэхгүй өнгөрөх; олон юмнаас онож сонгохгүй байх”.

“Der Groschen ist gefallen” (Аравтын мөнгө уналаа) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Нэг таавар таах, алив юмны учрыг олох гэж хэн нэгэн хүн их удвал “Аравтын мөнгө унатлаа удлаа” гэдэг. Олчихлоо таачихлаа гэвэл “Аравтын мөнгө уналаа” гэнэ. Энэ хэлц дээр үед автомат хайрцганд германы бутархай мөнгөний нэг “грошен” (аравтын мөнгө) хийхэд ууттай чихэр гардаг байсан үед гарчээ. Мөнгө доошоо унахад контакт үүсээд ууттай чихэр, буюу тэнд байрлуулсан өөр нэг юм унадаг байснаас үүдэлтэй. Мөнгө өндөр ханштай байсан цагийн нэг хэлц үг.

Одоогийн утга: Ойлгох, ухаарах, мэдэх

Монгол дүйцүүлэг: “ухааны нь олох; сэнхрэх; сэхэх”.

“Der springende Punkt” (Үсрэх цэг) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Эртний герегийн гүн ухаантан Аристотель нэг шийдвэрлэх зүйлийг олж мэджээ. Энэ нь өндөгний шараас шувуу бүрэлддэгийг олж тогтоожээ. Тэгээд хамгийн түрүү зүрх нь ажиллаж эхэлдэг байна.

Одоогийн утга: Зангилаа хэсэг, шийдвэрлэх цэг, гол зүйл, шийдвэрлэх фактор

Монгол дүйцүүлэг: “Учир начир; гол гогцоо; шийдвэрлэх зүйл”.

“Der Sündenbock sein” (Нүгэлт ухна болох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ нь гай зайлуулах еврейн ёсноос үүдэлтэй ажээ. Хоёр ухна сүргээс сонгож авчраад шодоод алинаар нь Яава бурханд өргөл өргөхийг шийддэг байжээ. Нөгөө нэгийг нь ламтан адислаад тэр тосгоны бүх хүний нүглийг үүрүүлээд элсэн цөлд аваачиж тавьдаг байжээ. Хөөрхий ямар ч нүгэл хийгээгүй нэг муу ухныг золигт гаргадаг байсан хэрэг.

Одоогийн утга: Буруугүй байж буруутан болох, бусдын хийсэн лайг эдлэх,

Монгол дүйцүүлэг: “Золигт гарах, золиос болох, бусдын бурууг үүрэх”.

“Der Vergleich hinkt” (Харьцуулалт доголдох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дээр үед “хазганах” гэдэг нэлээд түгээмэл шаналгаа байжээ. Түүнээс гадна тун ч олны анхаарал татсан зүйл, бүх эндүүрлийн эх булаг болдог байжээ.

Одоогийн утга: Тун тааруухан, тохирохгүй харьцуулал

Монгол дүйцүүлэг: “тэмээг ямаатай зүйрлэх; газар тэнгэр хоёрыг адилтгах”.

“Der Versuch, einen Pudding an die Wand zu nageln” (Ханан дээр зутан хадах гэж оролдох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Үл бүтэх юмаар оролдох, дэмий юманд цаг заваа барах гэсэн утгатай ажээ.

Одоогийн утга: Тун болохгүй юмыг болгох гэж оролдох

Монгол дүйцүүлэг: “Үхрийн эвэр дээр цас тогтоох; усан дээр гал түлэх, хадан дээр өвс ургуулах”.

“Der wahre Jakob” (Жинхэнэ Якоб) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ үг Апостель Якобусын тухай ажээ. Домогт гардгаар түүнийг Хойд Испанийн Сантиаго де Компостелад оршуулжээ. Бас европын олон сүм түүний шарилыг хадгалдаг хэмээн баталдаг гэнэ.

Одоогийн утга: Жинхэнэ (биш)нь, хамгийн сайн нь(биш), шилдэг нь биш), бүр гоё нь (биш)

Монгол дүйцүүлэг: “Жинхэнэ нь(биш); шилдэг нь(биш);сор нь биш”.

“Die Büchse der Pandora öffnen” (Пандорагийн хайрцгийг нээх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Пандора гэдэг нь энэ ертөнцийн анхны эмэгтэй гэнэ. Зойс хэмээх хамгийн том бурхан Пандорад нэг хайрцагтай юм өгчээ. Түүнийг Пандора хүн төрөлхтөнд өгөх ёстой байж тэгэхдээ онгойлгож үзэж болохгүй хэмээн хатуу анхааруулсан байна. Тэр эмэгтэй тэсэлгүй хайрцгийг нээвэл гай зовлон, золгүй явдал, гарз хохирол гээд болохгүй бүхэн гарчээ.

Одоогийн утга: Муу зүйл, гай зовлонгийн уурхай

Монгол дүйцүүлэг: “гай даллах; зовлон дуудах; түүгээр явсан гайг үүгээр дуудах”.

“Die Fäden ziehen” (Утас татах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хүүхэлдэйн театрт хүүхэлдэйнхээ толгой, гар, хөлөөс уясан утсыг татан хүүхэлдэйгээ хөдөлгөдгөөс гаралтай. Хүүхэлдэйнүүд өөрсдөө хөдлөөд яваад байх мэт байвч, тэдний толгой, ам, гар, хөл бүгд л бусдын эрхшээлд хөдөлж байдгаас үүдэлтэй ажээ. Харин тэдгээрийг хөдөлгөж байгаа эзэн өөрөө үзэгддэггүй билээ.

Одоогийн утга: Эрх мэдэлтэй байх, удирдах, нууцаар өөрт ашигтайгаар эргүүлэх

Монгол дүйцүүлэг: “жолоодох; далдаас удирдах; утсан хүүхэлдэй болгох”.

“Die Flinte ins Korn werfen” (Буугаа хөсөр хаях) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Буугаа хөсөр хаях” гэдэг хэлц дайны үеэс гаралтай. Ямар ч найдлагагүй тулалдаанд амиа золиослохоор зэвсгээ хаяад бууж өгсөн нь дээр. Ялангуяа хөлсний цэрэг тулалдаанд амиа золиосолсноос буугаа хаяад бууж өгөхийг илүүт үздэг үе байжээ. Итгэл үнэмшлээрээ биш мөнгөний төлөө байлдаж яваа тэдэнд утсан чинээ улаан амь нь юу юунаас үнэтэй байсан нь мэдээж.

Одоогийн утга: Болих, зориг мохох, бууж өгөх,

Монгол дүйцүүлэг: “хулхи нь буух; бууж өгөх; зориг мохох; шантрах”.

“Die Hunde bellen, die Karawane zieht weiter” (ноход хуцаж байна, жингийн цуваа цаашаа явж л байна) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Дорно дахин, ялангуяа монголчууд тэмээн жингээр алсыг зорино. Айлын ноход боргож байсан ч алсын замаа даган явж л байна. Их юмыг зорьсон бол бага сага юманд цаг гарздаж саатах хэрэггүй гэсэн санааг илтгэнэ.

Одоогийн утга: Хөндлөнгийн хүн юу ч гэж байсан зорилгоосоо бүү буц, их юмыг бүтээхээр зорьсон бол аахар, шаахар юмаар цагаа бүү гарзад.

Монгол дүйцүүлэг: “Айлын ноход боргож л байна. Аянчны цуваа явж л байна”.

“Die Katze im Sack kaufen” (Шуудайнд хийсэн муур худалдан авах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Зах дээрээс нэг эр өндөглөгч цагаан тахиа сонгон аваад савлуулж аваад “маргаашаас нь эхлээд өглөө бүр өндөг иднэ” хэмээн баяр хөөртэй гэртээ иржээ. Гэртээ ирээд шуудайныхаа амыг нээсэн чинь гурван гуринхалсан муур гарч ирсэн юм гэнэлээ.

Одоогийн утга: Харанхуйгаар худалдан авах, таньж мэдэхгүй зүйлд итгэх

Монгол дүйцүүлэг: “Хулхидуулах; сохроор авах; хонин толгой үзүүлж, нохойн мах зарах”.

“Die Katze lässt das Mausen nicht” (Муур хулгана барихаа больдоггүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хэн нэгэн хулгай хийсэн бол дахиад хийхгүй гэх үндэсгүй. Муур хулгана барихаа больдоггүйн адил. Муу зуршлаа хүн тавьдаггүй.

Одоогийн утга: муу зуршлыг орхиж болдоггүй

Монгол дүйцүүлэг: “сурсан занг сураар боож болдоггүй; чоно махнаас гарахгүй, сурсан занг хаалгаар хөөгөөд гаргахад тооноор үсрээд орж ирнэ”.

“Die Kirche im Dorf lassen” (Сүмийг тосгондоо үлдээх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Сүмийг тосгондоо үлдээх” гэвэл сүмээ тойрон гороолох хэрэгтэй, сүм суурингаасаа гараад явж болохгүй. Өөр тосгон руу орж болохгүй. Хийх юмаа л хий, хэтрүүлэх хэрэггүй.

Одоогийн утга: Ажил хэрэгтээ эргэж орох, бодит орчноосоо гарах хэрэггүй, хэр хэмжээндээ байх

Монгол дүйцүүлэг: “Рамандаа жайжигнах; адууныхаа хэрээр исгэрэх; хөнжлийн хэрээр хөлөө жийх”.

“Die Löffel spitzen” (халбага үзүүрлэх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Бид хоол идэх хэрэгслийг халбага гэдэг бол анчид туулайн чихийг халбага гэнэ. “Халбага үзүүрлэх” гэвэл чихээ соотойлгох гэж ойлгоно. Чимээ анир авах гэсэн үг.

Одоогийн утга: Анхааран сонсох, чих тавин чагнах, аманд нь орчих шахах

Монгол дүйцүүлэг: “чих тавин чагнах; чимээ анир авах; салхи авах; сонор соргог байх”.

“Die Ohren steif halten” (Чихээ босоо байлгах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц амьтны ертөнцөөс гаралтай. Адуу, илжиг, нохой зэрэг амьтан ямар нэг чимээ анир авбал чихээ соотойлгодог.

Одоогийн утга: Зоригтой байх, шантрахгүй байх, өөдрөг байх

Монгол дүйцүүлэг: “Үзэж алд, үл шантар, үзэж алдаж, үсэрч наалдах”.

“Die Spitze des Eisbergs” (Мөсөн уулын орой) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Мөсөн уулыг тойрч гарах боломжгүй. Титаник гэдэг тухайн үеийн зорчигч тээврийн хамгийн том хөлөг онгоц мөсөн уулын орой мөргөн 1912 оны 4-р сарын 14 –нд сүйрсэн түүхтэй. “Мөсөн уулын орой” гэдэг хэлцийг улс төрд их хэрэглэдэг. Тухайлбал газрын тосны хөлөг онгоц сүйрэхэд эд хөрөнгө үрэгдэх нь наад захын хэрэг. Асгарсан тос маш удаан хугацаанд далай тэнгисийг бохирдуулж, үлэмж хэмжээний хохирол учруулж далайн амьтан, ургамал, жигүүртэнг устгадаг.

Одоогийн утга: Нүүрлэж байгаа их хэмжээний гай зовлонгийн зах зух

Монгол дүйцүүлэг: “Муу юмны зах зух, муу юмны сэжүүр”.

“Drei Kreuze machen” (Гурван чагт тавих) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Аливаа таагүй зүйлийг гарз хохиролгүй давсан католик шүтлэгтэн ертөнцийн эзэндээ талархан мөргөдөг. Тэгэхдээ гарынхаа алгыг дэлгэн эхлээд духандаа, дараа нь тэгээд баруун зүүн цээжиндээ хүргэдэг байна.

Одоогийн утга: Болж өнгөрсөнд санаа амрах, ажлынхаа ард нь гарсанд тайвшрах,

Монгол дүйцүүлэг: “Даваагаа давах; айдгийгаа авдартаа хийх; чагталж авах”.

“Ein Buch mit sieben Siegeln” (Долоон лацтай ном) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Олон лацыг задалж байж, сая нэг апокалипсийг нээнэ. Сайн, муу хоёрын тэмцлийн эцэст ертөнцийн төгсгөл ирнэ. Апокалипсийн ёсоор Йоханнесийн дараа ертөнцийн эзний гүрэн эхэлнэ. Энэ үед шударга, амгалан цаг ирнэ. Тэр цагт ертөнцийн эзэн бүхнийг захирна гэсэн домогтой.

Одоогийн утга: Ойлгомжгүй, огт мэдэхгүй зүйл

Монгол дүйцүүлэг: “хальтлахгүй юм; гадарлахгүй юм; мэдэхгүй зүйл; мэддэггүйд эрээн цоохор”.

“Ein Ritt über den Bodensee” (Бөөдензее дээгүүр мориор гарах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Бөөдензее нуурын дээгүүр мориор аялсан нь” гэдэг дуурь. Өвлийн нэг өдөр Бөөдензее нуурын нөгөө талд яаралтай очих шаардлага гарсан нэгэн эр онгоц олдсонгүй тул мориор явж хүрчээ. Тэнгэр бүрхэг манантай байсан тул тэр эр хар баримжаагаар явж нуурын нөгөө талд гарчээ. Нуурын нөгөө хөвөөнд нэгэн

эмэгтэйтэй уулзаад хэрхэн хүрч ирснээ яривал тэр эмэгтэй ойр хавийн хүмүүсийг дуудан нуурын мөс олон газраа нимгэн тул мөс цөмөрч усанд үйж үхэж болох байсныг зэмлэн хэлэхэд нөгөө эр айсандаа ухаан алдан мориноосоо савж унасан гэдэг.

Одоогийн утга: Аюултай юм хийснээ хожуу мэдрэх

Монгол дүйцүүлэг: “Ниргэсэн хойно нь хашгирах; өнгөрсөн борооны хойноос эсгий нөмрөх; явсан зочинд таваг засах”.

“Ein Spatz in der Hand ist besser als eine Taube auf dem Dach” (Дээвэр дээрх тагтаанаас алган дээрх болжмор илүү) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Бүтэх эсэх нь эргэлзээтэй хэтийн юманд найдахаар одоо байгаа баттай юмыг авах нь дээр.

Одоогийн утга: Эрсдэлтэй хожмын их ашгаас найдвартай ойрын бага юм дээр, батгүй их юмнаас баттай бага юм дээр

Монгол дүйцүүлэг: “Маргаашийн өөхнөөс өнөөгийн уушиг; чамлахаар чанга атга”.

“Einen Floh im Ohr haben” (Чихэндээ нохой бөөстэй болох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Нохойн бөөс чихэнд орчхоод үсэрч цовхчоод байвал хүн тайван байж, юм бодож сэтгэж чадахгүй нь ойлгомжтой. Чихний нүхээр дамжаад тархинд хүрвэл бүр ч аюултай биз. Хүсэх ч юм биш.

Одоогийн утга: Ямар нэг юмаар хорхойсуулан хөөцөлдүүлэх, үл гүйцэлдэх юмаар хөөцөлдүүлж орхих

Монгол дүйцүүлэг: “Чулуу хөөлгөх; амар заяа үзүүлэхгүй зовоох; өдрийн бодол шөнийн зүүд болох”.

“Einen Kater haben” (Мууртай болох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хоолойны салст бүрхүүлийн өрөвслийг латинаар **“Katarrh”** гэнэ. Архи ууж шартсан хүн хоолой дээрээ ямар нэг өрөвсөлтэй юм шиг байдаг тул “миний хоолой өрөвсжээ” гэдэг байжээ. Цаг хугацаа өнгөрөхөд **“Katarrh”** нь **“Kater”**(муур) болж хувирчээ.

Одоогийн утга: Шартах, урд орой нь их архи уусны улмаас бие нь тавгүйтэх,

Монгол дүйцүүлэг: “Шартах; хоолойд эсгий гутал чихсэн юм шиг”.

“Einen Korb geben/bekommen” (сагс өгөх/авах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Эргүүлэхээр ирсэн залууг бүсгүй таалбал сагс буулган дотор нь суулгаад цонхоороо татаж авдаг байжээ. Гэтэл залуу эс таалагдвал жаахан дээш татсанаа унагаж орхиход бөгсөөрөө түс хийтэл унадаг байсан хэрэг. Охины унтлагын өрөөнд орох гэж их юм санасан эр маань бөгсөөрөө лаг хийтэл унах явдал гарна.

Одоогийн утга: Татгалзах, үл зөвшөөрөх,

Монгол дүйцүүлэг: “Царай өгөхгүй байх, нүүр өгөхгүй байх, санасны гарз болох”.

“Eine Gelegenheit beim Schopfe packen” (Цомцогдон авах боломж) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц герегийн эртний домгоос гаралтай ажээ. Энэ домогт аятай боломж олгодог Кайрос хэмээх нэгэн далавчтай бурхан гардаг. Тэр бурхан тун хурдан хөдөлдөг гэнэ. Тэр бурхныг барьж авах цорын ганц арга бол түүний духан дээрх цомцог үснээс нь базан авах гэнэ.

Одоогийн утга: Завшаан үл алдах, Боломж алдахгүй байх, аз жаргалыг амжиж хүртэх, сайхан боломжийг эс алдах

Монгол дүйцүүлэг: “Завшааныг ашиглах; боломжийг эс алдах; аманд орсон шар тосыг хэлээрээ түлхэхгүй байх”.

“Eine Krähe hackt der anderen kein Auge aus” (Хэрээ хэрээнийхээ нүдийг ухдаггүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц хэрээний овгийн шувууд ухаалаг гэдгээс гаралтай аж. Хэрээ насан туршдаа нэг л “ханьтай” явдаг гэнэ. Тэгээд ч хүн болон хүн сармагчны адил хүнс олж идэхдээ хамтран зүтгэдэг гэнэ. Бас хоёр гурван зуун жил насалдаг гэнэ.

Одоогийн утга: Мэргэжил нэгтэй, хамт ажилладаг хүмүүс нэг нэгнийгээ хамгаалдаг

Монгол дүйцүүлэг: “Айл хүмүүсийн амь нэг, ажил үйлс нэгтний санаа нэг”.

“Eine Prinzessin auf der Erbse sein” (Нэг ширхэг вандуй дээрх гүнж) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хатан хаан залуу бүсгүйн орон дээр нэг ширхэг вандуй тавиад дээрээс нь 20 ширдэг, хорин өдөн гудас дэвсэж өгчээ. Залуу бүсгүйг өглөө сэрэхэд нь хатан хаан сайхан унтав уу хэмээн асуувал: “Орон дотор нэг хатуу юм нухаад ерөөсөө ч унтуулсангүй” гэжээ. Нээрээн ч бүсгүйн бие газар сайгүй хөх толбо болж орхисон байжээ. Ийм их эмзэг, мэдрэмтгий, хорин ширдэг, хорин өдөн гудасны доор байгаа ганц вандуйг жинхэнэ гүнж л мэдэрч таараа хэмээн ихэд баярлажээ. Ийнхүү жинхэнэ гүнжтэй хан хүүгээ гэрлүүлсэн гэдэг.

Одоогийн утга: Тун эмзэг, өртөмтгий, сэтгэлийн хөдлөл ихтэй, өрөвжхөн

Монгол дүйцүүлэг: “Эмзэгхэн; энхрийхэн; уяхан; өрөвчхөн”.

“Eine Schwalbe macht noch keinen Sommer” (ганц хараацай гарч ирснээр зун болчихгүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хараацай дулаан оронд өвөлжөөд зундаа сэрүүн оронд ирдэг нүүдлийн шувуу. Ганц нэг хараацай хараад хавар болчихжээ хэмээн дүгнэж хараахан болохгүй. Олон хараацай тэнгэрт харагдаж байж сая хавар болсныг илтгэдэг.

Одоогийн утга: Яаран дүгнэлт хийх хэрэггүй, нэг үзсэн зүйлээ нийтэд хамааруулж болохгүй, хаа нэг тохиолдсон зүйлээ хамаг амьтанд хамааруулж болохгүй

Монгол дүйцүүлэг: “яарвал даарна, түрүүлж дуугарсан хөхөөний ам хөлдөнө, зай ч байна, лай ч байна”.

“Einem geschenkten Gaul schaut man nicht ins Maul” (Бэлгийн морины шүдийг үздэггүй) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Энэ хэлц ромын үеэс гаралтай, ромчуудад морьд чухал үүрэгтэй байсан нь мэдээж, энэ хэлц бас монголчуудын удам хүннү нараас гаралтай ч байж болох юм.

Одоогийн утга: Бэлгийг голж, сонжих хэрэггүй, зүгээр баярлан авах хэрэгтэй

Монгол дүйцүүлэг: “Бэлгийн морины шүдийг үздэггүй”.

“Einen Eiertanz aufführen” (Өндөг хоорондуур бүжиглэх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Нэг охин шалан дээгүүр түүхий өндөг тодорхой зайтай цувуулан тавиад нүдээ боолгоод хоорондуур нь бүжиглэхдээ нэг ч өндөг хагалаагүй байна. Үүнийг Германы алдарт яруу найрагч Йоханн Вольганг фон Гёте ихэд бахдан бичиж авчээ.

Одоогийн утга: Гарц хайх, юм нуух, далдлах, тодорхой юм хэлэхгүй булзах

Монгол дүйцүүлэг: “Булгах; булзах; далдлах; тодорхой цаг товлохгүй байх; тоймтой юм хэлэхгүй байх”.

“Einen Fuß in die Tür bekommen” (Хаалга, хатавцны завсар хөлөө тавьж авах) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Нэхэл хатуутай зарим худалдаачид зар сурталчилгаа өгөх, юмаа борлуулахаар хаалга тогшихоор гэрийн эзэн бушуухан хаалгаа хааж орхидог байна. Тэгэхлээр нь ирсэн хүн хаалганы завсар хөлөө тавиад ярих хэлэх гэсэн юмаа хэлэх боломжтой болно. Зорьсондоо хүрэхэд нэг алхам дөхлөө гэсэн үг.

Одоогийн утга: Нэг алхам ойртох, оролцуулахад хүргэх, үгүйсгэх аргагүй болгох, хөл тавьж авах

Монгол дүйцүүлэг: “хөл хавчуулж авах; хуруугаа хийгээд авах; цээжээ оруулаад авах”.

“Einen Ohrwurm haben” (Чимхүүр хорхой чихэнд орох) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Чимхүүр хорхой унтаж байгаа хүний чихэнд ордог хэмээн хүмүүс боддог. Гэхдээ энэ нь ямар ч гэм хоргүй амьтан ажээ.

Одоогийн утга: Санаа бодлоос гарахгүй, амархан тогтоогдох аялгуу, таатай хөгжим

Монгол дүйцүүлэг: “Чихэнд хоногшсон аялгуу; зөөлөн аялгуу”.

“Einen Stein im Brett haben” (хөлгийн магнайд чулуутай байх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

“Хөлгийн магнайд чулуутай байх” гэдэг хэлц үг дундад зууны үед шоотой хөлөгт тоглоом ид тоглож байх үед гарчээ. Хөлгийн магнайд хоёр чулуу зэрэгцүүлэн байрлуулсан хүн хожиход дөхөж очдог байна.

Одоогийн утга: Талтай байх, ивгээлд багтах

Монгол дүйцүүлэг: “Талтай байх; ивгээлд багтах, бурханы мэлмийд багтах; суганд нь багтах”.

“Einen Toast aussprechen” (Тоаст хэлэх) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Хэн нэгэн бэлгэ үг хэлэхээр хундага тулган ууцгаадаг. Тоаст гэдэг нь шарсан талх гэсэн үг. английн лордууд XIX зууны үед дарсаа амттай болгохын тулд шарсан талх хундагатай дарсандаа хийдэг байжээ. Шарсан талхтай дарс тулгах аа хэдийн больсон ч “тоаст хэлэх” гэдэг хэлц нь үлджээ.

Одоогийн утга: Хундага тулгахдаа хэлдэг үг, хэн нэгэнд эрүүл энхийг хүсэн хэлдэг үг

Монгол дүйцүүлэг: “Бэлгэ үг хэлж хундага тулгах; утгатай үг хэлж, улаан дарс татах, рашаан болох болтугай”.

“Einen Vogel haben” ((толгойдоо) шувуутай) гэсэн хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас:

Мухар сүсэгт ухаан муудах явдал шувуунаас үүдэлтэй гэнэ. Хүний толгойд шувуу үүрээ

засчихлаар уг хүн аливааг санаж, сэтгэхээ больдог гэнэ. Тийнхүү “толгойдоо шувуутай” гэдэг хэлц буй болжээ.

Одоогийн утга: Үүргээ ухамсарладаггүй, ёс суртахууныг мөрддөггүй хүнийг толгойдоо шувуутай гэдэг

Монгол дүйцүүлэг: “ухаанд нь ухна үхсэн, сэтгэлд нь сэрх үхсэн, ойлгомжгүй юм хэлэх”.

Дүгнэлт

Цаг хугацаа өнгөрөх тусам өвөрмөц хэлцийн утгыг ухаж бодолгүй хэлэх, хэрэглэх нь олонтаа тохиолдох болжээ. Жишээ нь **"урд хормойгоо авч хойд хормойгоо нөхөх"** гэж хэлэх нь элбэг. Уул нь аргал, түлээ хормойлох, дэвсэж, юм нүдэх зэрэгт урд хормой л хамгийн түрүүнд өртөж, урагддаг. Бас уулзсан хүнд урдаасаа бүтэн хувцастай харагдахыг хичээнэ. Тийм учраас урагдаагүй ар хормойгоо авч урагдсан урд хормойгоо нөхөн түр аргацаах гэсэн санаа. Тэгэхлээр хэлц үг маань **"ар хормойгоо авч урд хормойгоо нөхөх"** билээ. Тэгэхлээр өвөрмөц хэлц үгийн гарал үүслийг зөв ойлгож, зөв тайлбарлахын тулд аливаа өвөрмөц хэлц үгийнхээ гарал үүслийг сайн судалсан байх хэрэгтэй юм.

Бас онож хэлэхгүй олон үгээр нуршин тайлбарлахаар оносон ганц хэлц үг хэлэх нь илүү оновчтой, ойлгомжтой болдог.

Ном зүй

1. Хамгийн сайхан өвөрмөц хэлцүүд (Die schönsten Redewendungen) Impressum, 2008, garant Verlag GmbH Renningen номын арын нүүрэнд:
2. Ардын уран зохиолч Тангадын Галсан гуай бидний оникдот гэдгийг ингэж оноожээ.
3. Die schönsten Redewendungen, 2008, Garant Verlag GmbH Renningen
4. Pons Monsudar Deutsch Mongolisch Kompaktwörterbuch Понс, Монсудар, Герман-Монгол толь бичиг 1.Ausgabe 2008
5. Deutsch –Mongolisch, VEB Verlag Enzyklopädie Leipzig, 1981
6. Б.Катуу, Аман зохиол судлал, Улаанбаатар, 2010
7. Чой.Лувсанжав, Орос-Монгол өвөрмөц хэллэгийн толины удиртгал
8. Г. Аким, Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь,
9. Б.Катуу, Зүйр, цэцэн, мэргэн, сургаал үг, Аман зохиол судлал XXXI ,2010
10. Э.Равдан, Хэл соёлын шүтэлцээний тухай
11. Монгол хэл-соёлын дүйцэлгүй нэрийн монгол-франц тайлбар толь, Улаанбаатар, 2016
12. Европын улсуудын хэлний талаар Проф. Др. Беатрикс Кресстэй Бирктэй сурвалжлагч Грюлингийн хийсэн ярилцлагаас авав
13. Оросын нэрт хэл шинжээчдийн нэг, Г.О. Винокур: Тал 9